


ЦАЙР ОЛБОРЛОЛТ БА ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ



АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР
Уул уурхай, судалгааны хэлтэс
Статистик мэдээлэл судалгааны тасаг



**Зохиогчид:**

Судалгааны ажлыг удирдсан:

АМГ, УУСХ, СМСТ-ийн дарга

Б.Бямбадагва

АМГ, УУСХ, СМСТ-ийн ахлах мэргэжилтэн

Ц.Цэгц

Судалж гүйцэтгэсэн:

АМГ, УУСХ, СМСТ-ийн мэргэжилтэн

Ч.Навчаа

**Судалгааны ажлын талаархи санал хүсэлтээ
дараахь хаягаар ирүүлнэ үү.**


Монгол Улс, Улаанбаатар 211238, Шуудангийн салбар 38,
АМГ, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Баруун жигүүр, АМГ-ын байр Уул уурхай, судалгааны хэлтэс

Утас: 976-11-263709

Факс: 976-11-310041

E-mail: navchaa68@yahoo.com

Web page: <http://www.mram.gov.mn>



Гарчиг

1. Цайрын онцлог шинж ба ашиглалт
2. Цайр олборлолтын өнөөгийн байдал
3. Дэлхийн цайрын эрэлт хэрэглээ
4. Дэлхийн зах зээлийн цайрын үнийн байдал, хэтийн төлөв
 - 4.1 Үнийн хэтийн төлөв
5. Монголын цайрын ордууд ба нөөцийн байдал
 - 5.1 Монголын уул уурхайн салбарын цайр үйлдвэрлэлийн хэмжээ
 - 5.2 Цайрт минерал ХХК-ний үйл ажиллагаа
 - 5.3 Монгол улсын төсөвт цайрын баяжмалын үйлдвэрлэлээс орж буй орлого
6. Цайрын үнийн хэтийн төлөв бидний судалгаагаар
7. Мэдээллийн эх сурвалж



1.Цайрын шинж чанар ба хэрэглээ

Цайрын эдийн засгийн ач холбогдол бүхий эрдэс нь спалерит бөгөөд ихэвчлэн өнгөт металын ордод галенит, пирит, халкопириттэй хамт оршдог. Хүдэр дэх Zn:Pb -ийн харьцаа 4-өөс их байвал цайрын хүдэр гэж үздэг. Сфалерит нь ихэвчлэн 2% хүртэлх кадми агуулахаас гадна германи, галли, инди, талли агуулдаг. Цайрын хүдэр нь хар тугалганы хүдэртэй адил янз бүрийн гарал үүсэлтэй өнгөт металлын орд газарт тохиолддог. Дэлхийн Эдийн засгийн үр ашигтай цайрын нөөцийг ойролцоогоор 144 сая тн гэж тогтоосон. Цайр агуулсан нүүрс нь цайрын байж болох нэг эх үүсвэр бөгөөд түүнд агуулагдах цайрын хэмжээ хэдэн сая тн байх боломжтой.

Цайрын ихэнхийг буюу 47%-ийг цайрдахад, 19%-ийг хайлш үйлдвэрлэхэд, 14%-ийг цутгамал хийхэд, барилгын үйлдвэрлэлд болон зай хураагуурын үйлдвэрлэлд 7%-ийг нь хэрэглэж байна .

Цайр нь өнгөт металлуудаас хэрэглээгээрээ хөнгөн цагаан, зэсийн дараа 3-рт орж байна.


2.Цайр олборлолтын өнөөгийн байдал

Олон улсын хар тугалга ба цайрын судалгааны группын тооцоогоор 2009 онд дэлхий нийтэд олборлосон цайрын бүтээгдэхүүн 11,4 сая тн болж 2,6%-р буурсан. Австрали улс 1,25 сая тн цайр олборлож 15,3%-р буурсан. Энэ нь баруун Австрали дахь Lennard Shelf –н уурхай Австрали долларын өсөлт, металлын үнийн бууралтаас шалтгаалан хаагдсан нь үүнд ихээр нөлөөлсөн. Уурхайн хаалтанд Karok Pillara, Goongew ба Cadjebut ордууд хамрагдсан. Австралийн бусад нилээд хэдэн цайрын уурхай үнийн бууралтаас үйлвэрлэлээ зогсоосон. Үүнд Xstrata-н эзэмшдэг Queensland-д оршдог Handlebar Hill-н уурхайд 2009 оны зах зээлийн үнээс шалтгаалан 2 сараас техникийн засвар үйлчилгээ хийхээр шийдвэрлэсэн. 2010 оны 1 сарын сүүлчээс Mount Lsa дахь баяжуулах үйлдвэрийн бүтээмжийг дээшлүүлэхийн тулд үйл ажиллагааг дахин эхэлсэн.

Эдийн засгийн байдлаас үзэхэд Азийн цайрын олборлолт 4,6 сая тн-д хүрч 1%-р буурсан. Өмнөд Америкийн бүтээгдэхүүн 2%-р буурч 2,24 сая тн, Хойд Америкийн бүтээгдэхүүн бага зэрэг буурч 1,93 сая тн, Европийн бүтээгдэхүүн 1,3%-р буурч 1,06 сая тн, Африкийнх бага зэрэг нэмэгдэж 294,000 тн-д хүрсэн байна.



Дэлхийн цайрын үйлдвэрлэл, боловсруулсан бүтээгдэхүүн ба боловсруулсан бүтээгдэхүүний хэрэглээ, 2000-2009 он



2010 онд эхлэх цайр олборлох төслүүд

Нэгдүгээр хүснэгт

Төсөл	Эзэмшигч	Байрлал	Уурхайн төрөл	Бусад металл	Хөрөнгө оруулалт / сая. доллар/	Цайрын нөөц /тн/	Үйлдвэрийн хүчин чадал /тн/жил/
Hindustan Expansion	Hindustan zinc	Энэтхэг	Ил уурхай	Pb, Ag, Cd	900	16.933.000	200
Tennessee division	Nyrstar	АНУ	Гүний уурхай	Ge,Ga	78	989	130
Wolverine	Northwest Nonferrous Jinduicheng	Канад	Гүний уурхай	Pb,Ag,Au, Cu	250	712	54.4
Colquijra	Minera El Brocal	Перу	Ил уурхай	Pb, Ag, Cd,Au,Cu	200	9.025.000	30
Expansion	Bass Metals	Австрали	Гүний уурхай	Pb, Ag Au,Cu	13	125	18.55
Fossey / Hellyer/					1,441	27,784,000	431,950
Нийт							





Нэгдүгээр хүснэгтэнд үзүүлснээр дараагийн хэдэн жилд дэлхийн цайрын бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлыг жилд 432,000 тн-р нэмэхийн тулд 2 өргөтгөлийн ажил, 3 шинэ уурхайг ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн. Хэрэв бүрэн хүчин чадлаараа ажиллавал 2009 оны бүтээгдэхүүнээс 3,8%-р өсөх юм. Уурхайн олборлолтыг нэмэгдүүлэх, буурч буй агуулгыг нөхөх зорилготойгоор одоогийн байдлаар Xstrata-ийн Ontario дахь Kidd Greek-ийн уурхайн гүнзгийрэлтийг нэмэгдүүлэх, Аргентиний Mina Aguilar уурхайн өргөтгөл гэх мэт нилээд хэдэн өргөтгөлийн ажиллагаа эхлэхээр байна.

Цайр олборлох хүчин чадлаа нэмэгдүүлж буй үйлдвэрлэгчдээс Hindustan Zinc-ийн олон уурхайн өргөтгөл хамгийн том нь бөгөөд жилдээ 200,000 тн цайр үйлдвэрлэх чадалтай 2 шинэ бутлагч суурилуулах, Rampura Agucha, Sindesar Khurd уурхайн өргөтгөлийн ажил эхэлж байна. Ингэснээр компаний нийт хар тугалга ба цайрын бүтээгдэхүүн жилд 1 сая тн –с давж нэмэгдэх юм. Rampura Agucha өргөтгөл нь 2010 оны дунд үеэр дуусах төлөвлөгөөтэй бөгөөд Sindesar Khurd –н өргөтгөл ба Kayar-н эхлэлийн ажлыг нь 2013 оны сүүлчээр дуусгахаар төлөвлөсөн. Төслийн нийт хөрөнгө оруулалт нь 900 сая доллар хүрч байна.

Tennessee дэхь Nyrstar компани нь Clarksville Tennessee уурхайг Coy/Immel Tennessee уурхайн салбартай нийлүүлэн нэг уурхай болгон Clarksville-ийн хайлуулах үйлдвэрийг түүхий эдээр хангах төлөвлөгөөтэй байна. Nyrstar компани энэ 2 уурхайг 15 гаруй жил ажиллуулах, жилд 62% цайрын агуулгатай баяжмал 210,000 тн-г үйлдвэрлэхийн тулд 2010 оны сүүлчээр бүрэн ашиглалтанд оруулах зорилт тавьлаа. Дахин эхлүүлэх үйл ажиллагааны зардал 2010 онд 20 сая доллар болно. Glencore нь цайрын үнийн бууралтаас болж 2009 оны 2 сард Tennessee дэхь үйлдвэрлэлээ зогсоосон.

Yukon-д Jinduicheng Molybdenum and Northwest Nonferrous компани нь 2010 оны дундаас туршилтын бүтээгдэхүүн үйлдвэрлэх тул Wolverine-ний уурхайг ашиглалтанд оруулж байна. Yukon Zinc нь 250 сая долларын өртөгтэй энэ төслийг санхүүжүүлэхээр шийдсэн бөгөөд Wolverine уурхайн ТЭЗҮ-г 2007 оны 1 сард хийж дуусгасан



ба эхний 3 жилд бүрэн хүчин чадлаараа ажиллавал өдөрт 1700 тн гүний олборлолт хийн жилд 53,400 тн цайр, 4,860 тн зэс, 6,010 тн хар тугалга, 4,9 сая унц мөнгө, 20,200 унц алт зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой гэж үзсэн.

2009 оны 11 сард Minera El Brocal-н эзэмшил Colduijirca уурхай дахь Huaraucasa баяжуулах үйлдвэр нь 2010 оны 1 сард өдөрт 6,300тн бүтээгдэхүүн үйлдвэрлэж олборлолтоо нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. 2008 оны 8 сард Tajo Norte ил уурхайн бүтээгдэхүүнийг өдөрт 15,00 тн-д мөн Marcapunta Norte гүний уурхайн бүтээгдэхүүнийг өдөрт 3,000 тн-д хүргэн олборлолтыг өргөтгөх төлөвлөгөөтэй 200 сая долларын төсөл батлагдсан. Minera El Brocal нь хар тугалга-цайр-мөнгө ба зэсийн олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд Huaraucasa баяжуулах үйлдвэрийг орчин үеийн болгож өргөтгөхөөр төлөвлөж байна.

Bass Metals -ын Tasmania дахь Hellyer төсөл нь үйлдвэрлэлийн өмнөх шатандаа байгаа ба Bass Metals нь 2010 оны 1 сарын сүүлчээр Fossey уурхайг ашиглахаар шийдвэрлэж Nyrstar -тай хамтарч Hellyer үйлдвэрт цайр ба хар тугалганы баяжмал гаргах гэрээнд гарын үсэг зурсан. Жилд 400,000 тн хүдэр боловсруулах ажил 2010 оны 9 сард эхэлж 18,550 тн цайр, 10,420тн хар тугалга, 862,000 унци мөнгө, алт зэс гаргахаар төлөвлөж байна.

ILZSG (олон улсын хар тугалга, цайрын судалгааны групп)-н судалгаа 2009 онд дэлхий нийтийн цэвэр цайрын бүтээгдэхүүн 11,3 сая тн болж 3,2% -р буурсныг мэдээлсэн. Хятад улс тэргүүлсэн Азийн боловсруулсан цайрын үйлдвэрлэл 4,1%-р өсөж бусад цайр үйлдвэрлэх гол бүс нутаг Европ болон хойд Америкт тус тус 17,6% ба 12%- буурсан байна.

ILZSG- нь 2010 онд цайрын боловсруулсан бүтээгдэхүүн 12,26 сая тн-р өснө гэж таамаглаж байгаа энэ нь Хятад, Энэтхэг, Перуд нилээд ач холбогдол бүхий шинэ үйлдвэрүүд ашиглалтанд орох, 2009 оны 12 сард Nyrstar –ийн Balen-д боловсруулах үйлдвэр дахин ашиглалтанд орох, уналтанд орсон олон үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ нэмэгдүүлэх гэж байгаатай холбогдон энэ таамаглал гарчээ.



Боловсруулсан цайрын үйлдвэрлэл 2004-2009 он, Бүс нутгаар/мян.тн/

Хоёрдугаар хүснэгт

	2004	2005	2006	2007	2008	2009	% өөрчлөлт 2008-2009
Ази	4.918	5.052	5.555	6.191	6.579	6.850	4.1%
Европ	2.720	2.563	2.508	2.516	2.476	2.040	-17.6%
ХойдАмерик	1.496	1.411	1.378	1.401	1.380	1.214	-12.0%
Австрали	474	457	466	502	499	526	5.4%
Өмнөд Америк	497	468	490	470	461	392	-15.0%
Африк	260	273	257	279	260	265	1.9%
Нийт	10.365	10.224	10.654	11.359	11.655	11.287	-3.2%

Эх сурвалж-ILZSG

2009 онд Хятадын боловсруулсан бүтээгдэхүүн 4,4 сая тн болж 11%- р өсөж хэрэглээ нь 4,7 сая тн –с давж 18%-р өслөө. Цайрын баяжмалын импорт 1,7 сая тн-д хүрч 64%-р өсөж цэвэр балансын алдагдал 1,6 сая тн-д хүрсэн. Хятад улс 2002 оноос цайрын баяжмал экспортонд гаргаагүй байна.



3. Дэлхийн цайрын эрэлт хэрэгцээ

Гуравдугаар хүснэгтэнд үзүүлсний дагуу ILZSG-н судалгаагаар 2009 онд дэлхий нийтийн боловсруулсан цайрын хэрэгцээ 10,8 тн болж 5,2%- буурч түүний зах зээл дэхь илүүдэл 445,000 тн болсон. Азиас бусад бүх бүс нутгуудад хэрэглээ буурсан ба Хятад улс аж үйлдвэрийн тогтвортой байдалд байж цайрын хэрэгцээ нь 715,00 тн буюу 18%-р нэмэгдэж 4,73 сая тн-д хүрсэн. Азийн цайрын хэрэгцээ 6,97 сая тн-д хүрч 6,2%-р нэмэгдсэн. Бусад гол хэрэглэгч бүс нутаг болох Европ ба хойд Америкт тус бүр 25% ба 12%-р, Өмнөд Америкт 26%, Африк 13%, Австрали 14%-р буурсан байна.

ILZSG-н судлаачид 2010 онд ихэнх оронд цайрын хэрэгцээ нэмэгдэх боловч ихэнх тохиолдолд 2008 оны хэрэгцээнээс доогуур байна гэж үзэж байна. Эдгээр өсөлтийг Хятадад 7,6% Энэтхэгт 10,6%-р өсөх тооцоотой хослуулан дэлхий нийтийн цайрын хэрэгцээ жилд 12,04 сая тн болж 11%-р нэмэгдэнэ гэж таамаглаж байна.


Боловсруулсан цайрын хэрэгцээ 2004-2009 он, Бүс нутгаар/мян.тн/

Гуравдугаар хүснэгт


	2004	2005	2006	2007	2008	2009	% өөрчлөлт 2008-2009
Ази	5,230	5,572	5,746	6,148	6,566	6,970	6,2%
Европ	2,837	2,684	2,786	2,858	2,620	1,964	-25,0%
Хойд Америк	1,680	1,497	1,584	1,434	1,414	1,239	-12,4%
Австрали	446	403	433	443	445	330	-25,8%
Өмнөд Америк	194	204	199	210	197	172	-12,7%
Африк	263	253	268	214	194	167	-13,9
Нийт	10,650	10,613	11,016	11,307	11,436	10,842	-5,2

Эх сурвалж-ILZSG

Европ болон Япон дахь цайрын эрэлт хэрэгцээ,
2003-2009 он



Хятадын барилгын салбар дахь
металын хэрэгцээ






Дэлхийн металын хэрэгцээ Хятадын барилгын салбарын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай байна. Металлын статистик судалгааны сүүлийн үеийн мэдээллээс харахад Хятадын барилгын салбарт Төмөр, Цайр, Зэс, Хөнгөн цагаан гэх мэт зарим металлын хэрэгцээ нилээд их байгааг үзүүлж байна.

4. Дэлхийн зах зээлийн цайрын үнийн байдал, хэтийн төлөв

Сүүлийн үеийн үнийн байдал

2009 онд Лондонгийн металлын бирж дээр цайрын дундаж үнэ 0,75 ам.долл/фунт болж 2008 оны дундаж үнэ 0,85 ам.долл/фунт-с 12%-р буурсан. 2009 оны сүүлд цайрын нөөц 489,100 тн болж 93%-р өссөн нь 2005 оны 9 сараас хойшхи хамгийн өндөр үзүүлэлт байлаа. Үйлдвэрлэл ба барилгын салбар дахь цайрын хэрэглээ буурснаар 2009 онд цайрын нөөц нэмэгдсэн. Цайрын нөөц өссөн ч 2008 оны дундаж үнэ 0,50 ам.долл/фунт нь 2009 оны 12 сард 1,08 ам.долл/фунт хүрч 2 дахин өссөн нь цайрын үнийн уян хатан байдлыг үзүүлсэн. Энэ өндөр үнийг хөрөнгө оруулагчид нь хянаж байна гэж судлаачид үзсэн. 2009 онд цайрын хэрэглээ 23%-р өссөн ч 2008 оны хэрэглээнээс 17%-р буурсан. Хятадын автомашины үйлдвэрлэл нэмэгдсэн нь 2009 онд цайр ба хар тугалганы хэрэглээг нэмэгдүүлсэн. 2010 оны 1 сард цайрын үнэ 1,1 ам.долл/фунт байсан ба 2 сард Лондонгийн металын бирж дээр 44000 тн цайр гэнэт нэмэгдсэний зэрэгцээ хэрэглээ нь багасаж цайрын үнэ 11%-р буурч 0,97 ам.долл/фунт болсон. 3 сард цайрын дундаж үнэ 1,03 ам.долл/фунт болж 5,5%-р өссөн байна.

1998 оны 3 сараас 2010 оны 3 сар хүртэлх Лондонгийн Металлын Биржид худалдаалагдсан цайрын нөөц ба үнийн байдал



4.1 Үнийн хэтийн төлөв

2010 оны 1 сард Reuters үндсэн металлуудад хийсэн 50 орчим судлаачийн үнийн таамаглалыг мэдээлжээ. Reuters нь 2010 онд цайрын дундаж үнэ 2,293 ам.доллар /тн, 2011 онд 2,523 ам.доллар/тн болно гэж таамаглаж байна.

Natixis Commodity Markets нь сүүлийн Metals Review-ийн дугаартаа 2010 онд металын нөөцийг худалдаж авах нь үргэлжилж, Хятадын эдийн засгийн өсөлт нь бусад газрын сулхан өсөлтийг нөхөснөөр цайрын үнийн байдал дахин сэргэнэ гэж урьдчилан мэдээлж байна. Natixis 2010 онд цайрын дундаж үнэ 2,800 ам.доллар /тн, 2011 онд 3,060 ам.доллар/тн болно гэж үзлээ.



MF Global 2010 оны 1 сарын Base Metals Outlook сэтгүүлдээ дэлхийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн сэргэлтийн шатандаа байгаа ба 2010-2011 онд 4-5% өснө мөн цайрын үнэ жигд тогтвортой байна гэж дурдсан. 2010 оны үлдсэн хэсэгт одоогийн түвшнээс бага зэрэг бууж жилийн дундаж үнэ нь 2,286 ам.доллар/тн, 2011 онд дунджаар 2,450 ам.доллар/тн болно гэж үзжээ.

Virtual Metals: Цайр Үйлдвэрлэгчид хэрэглээ хоцорч байхад бүтээгдэхүүнээ хэтэрхий хурдан нэмж байсан болохоор VM нь 2-3 сард цайр их хэмжээний илүүдэлтэй байна гэж тооцсон. Nyrstar, Teck, Boliden, Mitsui болон өөр бусад уурхайнууд дахин ашиглалтанд орж мөн хятадын бүтээгдэхүүнийг өнгөрсөн онтой харьцуулахад 2010 оны 2 сард 363,000тн болж 37%-р , 2010 оны 1 сард 60%-р 2009 оны 12 сард 47 %-р өссөн гэсэн мэдээг нэмснээр нийлүүлэлт маш их болсон. Хойд Хятадын дулаан цаг агаарын нөлөөгөөр үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж уурхайн бүтээгдэхүүн нэмэгдэх нь үргэлжилнэ гэж VM үзэж байна.

VM нь 2009 онд цайрын хэрэглээ 5%-р буурсан бол 2010 онд 7% -р өснө гэж тооцсон ба 2010 онд цайр нийлүүлэлт 3,4%-р өснө гэсэн таамаглал гаргажээ.

VM нь 2010 онд 3 сарын цайрын дундаж үнэ 2,278 ам.доллар / тн 2011 онд 2,825 ам.доллар/ тн байна гээд. Дэлхийн эдийн засгийн хямрал, Хятадын эдийн засгийн өсөлтийн зогсолт гэсэн 2 хүчин зүйлээс хол байж чадвал эрсдэлд орохгүй гэж дурьджээ.

Bank of America/Merrill Lynch нь 2010 оны 3 сарын 12-ний Global Metals Weekly –д төмрийн үйлдвэрийн дутмаг үйл ажиллагаанаас болж 2007 оноос хойш цайрын хэрэглээ сул байсан гэж тэмдэглэсэн байна. Merrill Lynch нь цайрын зах зээл дээр мэдээлэгдээгүй нөөц байгаа ба их хэмжээний метал гарч ирвэл үнийн сэргэлтийг удаашруулна гэж тэмдэглэж байна.

Bank of America/Merrill Lynch 2010 онд цайрын дундаж үнэ 2,125ам.доллар/тн н, 2011 онд үнэ нь нэмэгдэн 2,750 ам.доллар/тн байна гэж таамаглаж байна.

5.МОНГОЛЫН ЦАЙРЫН ОРД ГАЗРУУД БА НӨӨЦИЙН БАЙДАЛ

Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн судалгааны одоогийн түвшинд цайр, хар тугалганы 15 орд, 120 орчим илрэл нээгдэн судлагджээ. Дараахь хүснэгтэд эдийн засгийн ач холбогдол бүхий цайрын орд газрыг нөөцийн хамт үзүүлэв.

	Ордын байрлал	Үндсэн метал	Дагалдах метал	Балансын хүдэр (мян.тн)	Балансын метал (мян.тн)
1.	Баян-өлгий аймаг, Толбо сум, Хөх адар		Цайр	32362,75	409,53
2.	Хэнтий аймаг, Өмнөдэлгэр сум, Мөнгөн өндөр		Цайр	7156,5	135,4
3.	Дорнод аймаг, Чойбалсан сум, Цав	Цайр		3490	123,3
4.	Дундговь аймаг, Говь-Угтаал сум, Хараат уул		Цайр	37746,7	284,34
5.	Дорнод аймаг, Дашбалбар сум, Улаан	Цайр		38095,9	738,4
6.	Сүхбаатар аймаг, Түвшин ширээ сум, Эрдэнэ-Өндөр		Цайр	2204	58,19
7.	Дундговь аймаг, Говь-угтаал сум, Зүүн Төмөртэйн	Цайр	Төмөр	704,1	23,41
8.	Сүхбаатар аймаг, Сүхбаатар сум, Төмөртэйн Овоо	Цайр	Кадми	7689,4	885,3




5.1 Монголын уул уурхайн салбарын 2005-2010 оны цайрын үйлдвэрлэлтийн хэмжээ



5.2 Цайрт минерал ХХК-ний үйл ажиллагаа


Цайрт минерал ХХК нь Монгол улсад цайр олборлох үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын гол төлөөлөгч юм.

Төмөртийн овооны орд нь төмөр-цайрт шохойлог скарн ордын гол төлөөлөгч бөгөөд “Цайрт минерал” ХХК нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах уг ордыг үйлдвэрлэлийн аргаар эзэмших, ашиглах төслийг 2005 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд тус компаний 2005-2009 оны хүдэр боловсруулалтын хэмжээ, цайрын баяжмалын борлуулалтын хэмжээ ба борлуулалтын үнийг тус тус үзүүлэв.






Цайрын баяжмалын борлуулалтын үнэ



Цайрт минерал ХХК нь 2010 онд хүдэр дэхь цайрын агуулга буурч үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ буурна гэж үзэж байна.

5.3 Монгол улсын төсөвт Цайрын баяжмалын үйлдвэрлэлээс орж буй орлого



Монгол улсын нутаг дэвсгэр дээр цайрын баяжмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Цайртминерал ХХК, Шанлун ХХК гэх мэт байгууллагууд нь Монгол улсын татварын ерөнхий хуулийн 7-р зүйлд заагдсан улсын болон орон нутгийн татвар, төлбөр, хураамжуудыг төлж улсын төсөвт орлого оруулж байна.

Зарим татвар, төлбөр, хураамжийн төрөл, хувь хэмжээ:

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /25 %/
2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /5 %/
3. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
4. Газрын төлбөр / суурь үнэлгээний 0.01-0.03 %-иар/
5. Нэмэгдсэн өртгийн албан татвар
6. Импортын барааны гаалийн татвар



7. Экспортын барааны гаалийн татвар
8. Онцгой албан татвар
9. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар /үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний 0.6 %-иар/
10. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр
11. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
12. Төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр
13. Гадаад мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр
14. Авто зам ашигласны төлбөр
15. Гаалийн үйлчилгээний хураамж

Дээрхи татвар, төлбөр, хураамжийг төлөхөөс гадна тухайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн төсөвт хандив, тусламж өгч байна.


Цайрын баяжмалын үйлдвэрлэлээс орж буй төсвийн орлогыг дараахь хүснэгтэд үзүүлэв.



АМГ-Цайрын үнийн хэтийн төлөв

2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010
1128	886.3	778.5	828.4	1048	1382	3272.6	3250	1870.1	1658.9	2150

2010 онд цайрын дундаж үнэ 2150,5 ам.доллар/тн болсон ба 2009 оны дундаж үнэтэй харьцуулахад 29,6 %-р, 2008 оны дундаж үнэтэй харьцуулахад 14,9 %-р нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



2009 онд Лондонгийн Металлын Бирж дээр цайрын нөөц 235600 сая/т-р нэмэгдэж цайрын зах зээл их хэмжээний илүүдэлтэй байсан ба 2010 онд мөн их хэмжээний илүүдэлтэй байх төлөвтэй байна. Азид гарч ирж буй зах зээлийн өсөлтийн улмаас цайр удаан хугацаанд өндөр үнэтэй байж эрэлт хэрэгцээ нь өснө.

Дараахь хүснэгтүүдэд 2010 оны 11 сарын 30 хүртэлх цайрын үнийг 2009 оны мөн үетэй, 2010 оны 9,10,11 сарын цайрын үнийн харьцуулалтыг үзүүлэв.




	2009.I-XI	2010.I-XI	2010/2009
Дундаж	1,589.31	2,147.40	35.1%
Хам.их	2,330.50	2,634.25	13.0%
Хам.бага	1,059.25	1,594.75	50.6%

2010.IX	2010.X	2010.XI	X/IX	XI/X
2,151.00	2,371.79	2,291.14	10.3%	-3.4%
2,236.75	2,556.25	2,517.25	14.3%	-1.5%
2,088.75	2,192.75	2,078.25	5.0%	-5.2%

2010 оны 6 сараас цайрын үнэ нэмэгдсээр 2560 ам.доллар /тн хүрч энэ үнэ 11 сарын 10 хүртэл үргэлжилсэн ба 2010 оны 12 сарын 13-ны байдлаар 2322 ам. доллар /тн байна. Лондонгийн металын биржийн цайрын нөөц 11 сараас эхлэн нэмэгдсээр 12 сарын 15-ны байдлаар 630000 тн нөөцтэй байна.

2010 оны эхний хагаст дэлхий нийтийн цайрын үйлдвэрлэл 6241 сая тн болж 2009 оны мөн үеийнхээс 17%-р өссөн байна. Цайрын хэрэглээ 6047 сая тн болж 13%-р өссөн байна. 2010 оны эхний хагаст дэлхийн цайрын зах зээл 176000 тн-н илүүдэлтэй байна.





Сүүлийн үед цайрын хэрэглээ гангийн хэрэглээтэй хамааралтай байгаа ба гангийн хэрэглээ нэмэгдэхэд цайрын хэрэглээ нэмэгдэж байна. Өнгөрсөн жил нилээд их цайрын уурхай хаагдаж засварт орж байсан бол одоогийн үнийн байдлаас шалтгаалан бүх уул уурхайн компаниуд ашигтай ажиллаж эхэлж байна. Цайрын үнэ 2008 оны 12 сараас эхлэн нэмэгдсээр одоогийн байдлаар 150% нэмэгдээд байна. Хятад болон зүүн өмнөд азийн орнуудад цайрын хэрэглээ барилга болон автомашины үйлдвэрлэлд ихээр нэмэгдэж байна. Бидний хийсэн судалгаанаас үзэхэд дэлхийн зах зээл дээр 2011 онд цайрын үнэ 2100-2400 ам.доллар/тн-н хооронд хэлбэлзэх төлөвтэй байна.

Ашигласан материал:

Metal Economics Group

<http://www.metaleconomics.com/>

Metalprices

<http://www.metalprices.com/>

ILZSG

International Lead and Zinc Study Group

USGS

United States Geological Survey

АМГ, УУСХ

2009 оны Уул уурхайн салбарын

бүтээгдэхүүн гаргалт

Цайрт Минерал ХХК

2005-2009 оны олборлолт ба борлуулалтын

тухай мэдээлэл



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.
Утас: 319658, 320807, 321316
Вэб хаяг: www.munkhiin-useg.mn